



САЙН ТУРШЛАГА

“Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог
дэмжин ойн нөхөрлөлийг хөгжүүлэх”

ТӨВ АЙМАГ



Төв аймаг:




1. Нутаг дэвсгэр: 74 042.37 км²,
2. Газрын тогтоц: дтд- 1200-1500 м,
3. 16.4% ой мод, 36.5% хээрийн бүс,
4. Хиллэдэг аймаг: Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ
5. Ойн сангийн нийт талбай:
1 388 199 га /18.7%/
6. Хамгаалалтын бүс:
1 221 360 га буюу 87.98%
7. Ашиглалтын бүс:
1 66 839 га буюу 12.02%



Төв аймгийн хүн амын байдал /2018 оны жилийн эцсийн байдлаар/

95 045 иргэн






Төв аймгийн хүн амын байдал /2018 оны жилийн эцсийн байдлаар/





Туршлага хэрэгжүүлэх үндэслэл:



- ❖ Зөвшөөрөлгүй мод бэлтгэл
- ❖ Хулгайн ан агнуур
- ❖ Хог хаягдал
- ❖ Ойн нөхөрлөлийн үйл ажиллагааны 70%-ийг эрчүүд эрхэлдэг байсан
- ❖ Ойн цэвэрлэгээнээс бусад нэмэлт орлого олох боломж хомс байсан
- ❖ Ойгоос хаягдал бүтээгдэхүүн их байсан
- ❖ Байгалийн дагалдах баялгийг ашиглах мэдлэг хомс
- ❖ Иргэдийн холбогдох хууль эрх зүйн талаар мэдлэг, мэдээлэл дутмаг




Төв аймаг:

Нөхөрлөлийн тоо: 148


Үүнд:

1. Батсүмбэр сумын 39,
2. Баяндэлгэр сумын 3,
3. Баянцогт сумын 7,
4. Баянчандмань сумын 4,
5. Борнуур сумын 19,
6. Мөнгөнморьт сумын 24,
7. Жаргалант 47,
8. Угтаалцайдам сумын 1,
9. Эрдэнэ сумын 4





Сайн туршлагыг хэрэгжүүлэх орон нутаг: Борнуур сум



1. Нутаг дэвсгэрийн хэмжээ: 114 мян га,
2. Ойн сан: 34 655 га,
3. 19 нөхөрлөл, 321 гишүүнтэй/ 142 өрхийн 321 гишүүнээс эм –153, эр-168 байдаг.

Зорилтот нөхөрлөл:

1. Арангат хайрхан
2. Халиун буга
3. Эрдэнэ хайрхан
4. Суварга хайрхан

57 идэвхитэн байгаль хамгаалагчийн 20 нь эмэгтэй , 7 морин эргүүл байнга ажилладаг. /- 29311 га ойн санг харж, хамгаалдаг



Сайн туршлагыг хэрэгжүүлэх хүрээнд:

■ Зорилго:

Ойжуулалт, ой хамгаалал, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын асуудлыг хэрэгжүүлэхэд оршино.

Зорилт:

- Ойжуулалт, ой хамгаалал, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцох, байгалийн үр шимээс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх,
- Байгаль орчны салбарт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцох боломжийг нэмэгдүүлэхэд харилцагч байгууллагуудын хамтын ажиллагааны уялдаа, үр өгөөжийг сайжруулах,



Хийгдсэн арга хэмжээнүүд:

- “Жендэрийн анхан шатны сургалт”, “Нөхөрлөлийн гишүүдийн үүрэг оролцоог дээшлүүлэх, эрх зүйн сургалт” зэргийг 19 нөхөрлөлийн 315 /эр-156, эм- 159/ гишүүнд, зохион байгуулж 1.2 сая ₮ зарцуулсан.
- “Гэр бүл, амьдрах ухааны чиглэлийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх” чиглэлээр байгалийн дагалдах баялгийг ашиглан гар урлал хийх, эмийн ургамал түүх, савлах, хадгалах, борлуулах сургалтыг 19 нөхөрлөлийн 135 /эр-71, эм- 64/ гишүүн хамрагдаж гарын авлага тараан 250 000₮ зарцуулсан.
- “Хог хаягдлыг дахин боловсруулах” чиглэлээр сургалт зохион байгуулж 19 нөхөрлөлийн 243 /эр-109, эм- 134/ гишүүн хамруулж Байгаль хамгаалах, нөхөн сэргээх сангаас 130 000 төгрөгийн зарцуулсан.





Хийгдсэн арга хэмжээнүүд:

- 2019 онд 10 ойн нөхөрлөлийн 65 гишүүн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдааг 3 удаа зохион байгуулж оролцсон нөхөрлүүдэд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 500,0 ₮-ийг зарцуулж 3 нөхөрлөлийг шагнаж урамшуулсан.
- Мөн ойн дагалт хаягдал материал ашиглан хийсэн гар урлал, бусад 15 төрлийн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гарган Ази номхон далайн 32 орны байгль орчны төлөөлөгч нарт сумын ойн нөхөрлөлийн үйл ажиллагааны сайн талыг түгээн дэлгэрүүлэх ажлыг танилцуулав.





Хийгдсэн арга хэмжээнүүд:

- Зөрчил болон түймрээс сэргийлэх ойн морин эргүүл - 25 удаа хийсэн.
- 25 самбар, 4 нөхөрлөл гал унтраах багаж хэрэгсэлийн бүрдэл ханган ажиллаж байна.
- Ойн судалгаа хөгжлийн төвийн 10.4 сая төгрөгийн санхүүжилтээр “Сайхан санаа” мэргэжлийн байгууллагатай хамтран 9-р сард шатсан ойн санд 15 га талбайд 4 нөхөрлөлийн 25 /эм-12, эр-13/ гишүүн ойжуулалт хийв.
- Сумын БХНСЗардлаар /6.9 сая төг/ шатсан ойн санд 10 га талбайд Ойн таксади мэргэжлийн байгууллагатай хамтран 10-р сар ойжуулалт хийв.





Хийгдсэн арга хэмжээнүүд:



- Төв аймгийн Аргалант суманд зохион байгуулсан “Төв цэнгэл наадам”-аар сумын “Халиун буга” ойн нөхөрлөл байгалийн хаягдал бүтээгдэхүүнээр гар урлалын зүйл хийж үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож МҮОНТ, аймгийн Төв телевизд ярилцлага өгч олон нийтэд суртчилагдсан.
- Тив аймаг Борнуур сум хаягаар ойн нөхөрлөлүүдийн хийсэн ажлын тайлан, үр дүнг 6 удаа байршуулан 710 хандалт авсан.



Хийгдсэн арга хэмжээнүүд:



- **Жендерийн үндэсний хорооноос мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх уулзалтыг зохион байгуулж сайн туршлага хэрэгжүүлэх үйл ажиллагааг баримтжуулах үйл ажиллагаанд 3.0 сая ₮-ийн дэмжлэг үзүүлэв.**



Хийгдсэн арга хэмжээнүүд:



- **Сайн туршлагыг турших ажлын хүрээнд нөхөрлөлүүдийн талаар суурь мэдээлэл цуглуулж үйл ажиллагааг баримтжуулах зорилгоор Борнуур суманд ойн нөхөрлөлүүд болон сумын удирдлага, холбогдох мэргэжилтнүүд нийт 50 хүн хамруулан уулзалт, ярилцлага зохион байгуулсан.**



Хийгдсэн арга хэмжээнүүд:

- Сайн туршлагыг баримтжуулах үйл ажиллагаа:






Ололттой тал:

- Холбогдох мэргэжилтнүүд болон нөхөрлөлийн гишүүдийг сургалтад хамруулж, мэдлэг, мэдээллээр хангасан.
- Байгаль хамгаалах үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж, хамтын хүчээр ажиллаж зохион байгуулалт сайжирсан.
- Байгалийн дагалдах баялгийн ашиглах мэдлэг сайжирч бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэж 36 өрхийн орлого нэмэгдсэн.
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангаснаар ой нөхөрлөлийн үйл ажиллагаа идэвхжсэн.
- Ойн сантай холбоотой хууль бус үйл ажиллагаа буурсан.
- Иргэдийн болгоомжгүй үйлдлээс гардаг ой хээрийн түймрийн гаралт буурсан.



Тулгамдсан асуудал:

- Бүтээгдэхүүн борлуулах боломж дутмаг,
- Ойн нөхөрлөлүүдийн санхүүгийн чадавхи сул,
- Нутгийн удирдлагын шийдвэр гаргах түвшин, дэмжлэг үзүүлэх боломж бололцоо хомс



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.